

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар



**ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ,
ЗАРЦУУЛАЛТ**

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН НЬ ОНОГДУУЛСАН ТОРГУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ ТАВЬЖ, БИЕЛЭЛТИЙГ ХАНГАЖ АЖИЛЛААГҮЙГЭЭС 2023-2024 ОНД 708.1
САЯ ТӨГРӨГИЙГ ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

АУДИТЫН КОД: ХЭА-2025/27-21-ШТА-ГА

Чингис хот 2025 он
Цахим хуудас: www.open.audit.mn

Дарга, тэргүүлэх аудитор Ж.Ганбаатар
Утас: 70562112 Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn
Аудитын менежер Д.Оюунтуяа
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn
Ахлах аудитор Г.Энх-Амгалан
Утас: 91119424 Цахим хаяг: enkh-amgalang@audit.gov.mn
Аудитор Х.Еркегүл
Утас: 99040705 Цахим хаяг: erkegulkh@audit.gov.mn
Аудитор Х.Баярбаатар
Утас: 99040705 Цахим хаяг: bayarbaatarkh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
khentii@audit.gov.mn хаягаар авна уу.

Тайланг бэлтгэсэн:
Хэнтий аймаг дахь
Төрийн аудитын
газар

Дарга, тэргүүлэх
аудитор
Ж.Ганбаатар

Аудитын менежер
Д.Оюунтуяа

Ахлах аудитор:
Г.Энх-Амгалан
Аудитор:
Х.Еркегүл
Х.Баярбаатар

2025 оны 08 сар

Аудитын тайлан,
дүгнэлттэй
холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70562147, 70562112
дугаарын утас,
khentii@audit.gov.mn
хаягаар харилцана
уу.

ХАЯГ: Хэнтий
аймгийн Хэрлэн сум,
аймгийн ЗДТГ-ын
байр, 322 тоот

АГУУЛГА

АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ	4
Аудитын зорилт:	5
Хамарсан хүрээ:	5
Аудитын арга зүй:	5
Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:	6
Үндсэн мэдээлэл:	6
БҮЛЭГ 1. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР НЬ ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ СУДАЛГААНД ҮНДЭСЛЭН БОДИТ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГАД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.	7
А.1. Торгуулийн орлогыг бодит хэрэгцээ шаардлагад нийцүүлэлгүй авто замын сан болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулахаар төлөвлөж байна.	7
А.2. Торгуулийн орлогыг судалгаанд үндэслэн төлөвлөхгүй байна.	8
А.3. Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлттэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг сайжруулах шаардлагатай байна	9
Б. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАНУУД ОНОГДУУЛСАН ТОРГУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ АЖИЛЛААГҮЙГЭЭС 2023-2024 ОНД 508.4 САЯ ТӨГРӨГИЙН ОРЛОГЫГ ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА. ..	10
Б.1. Эрх бүхий албан тушаалтанууд орон нутгийн төсөвт төвлөрүүлэх 508.4 сая төгрөгийн торгуулийн орлогыг барагдуулаагүй, 50.4 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт шилжүүлсэн байна.	10
Б.2. Замын сан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг хуулийн дагуу бүрдүүлж байгаа эсэх нь тодорхойгүй байна.	11
В. АЙМГИЙН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 25 АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЖЭЭГҮЙ, ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДААГҮЙ 8 АРГА ХЭМЖЭЭНД 40.8 САЯ ТӨГРӨГИЙГ ЗАРЦУУЛСАН БАЙНА.	11
В.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд батлагдсан төсвийн 21.9 хувийг төлөвлөөгүй арга хэмжээнд зориулалт бусаар зарцуулсан байна.	11
Г. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТЭД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА. ..	15
Г.1. Хүү, торгуулийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бий болгож ногдуулалт, бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.	15
Г.2. Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлтэд хяналт хэрэгжүүлээгүй байна.	16
ДҮГНЭЛТ	18
ИРҮҮЛСЭН САНАЛ.	24

Хүснэгтийн товъёг	
Хүснэгт №1	Хэнтий аймгийн төсвийн орлогын ангилал
Хүснэгт №2	Торгуулийн орлогын төлөвлөлт
Хүснэгт №3	Орон нутгийн хүү, торгуулийн бүрдүүлэлт
Хүснэгт №4	Эрх бүхий байгууллагын торгуулийн оногдуулалт, тайлант оны төвлөрүүлэлт
Хүснэгт №5	ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилтийн судалгаа
Хүснэгт №6	Төлөвлөөгүй арга хэмжээг санхүүжүүлсэн дүн
Хүснэгт №7	Санхүүжилтийн зарцуулалт, байгууллагаар
Хүснэгт №8	Зардлын ангилал
Хүснэгт №9	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулсан зардлыг хүн амын тоонд харьцуулсан судалгаа

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААН	Аж ахуйн нэгж
ГХУСАЗСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
ГХУСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУ	Монгол улс
СЯ	Сангийн яам
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар

АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 08 дугаар сарын 15

Дугаар А/36

Чингис хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов "Эрх шилжүүлэх тухай" 2023 оны А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, хүргүүлсэн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Нийслэлийн дэх Төрийн аудитын газар, аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Засаг дарга, холбогдох бусад байгууллагад тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор /Г.Энх-Амгалан/-д даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

АУДИТЫН ТАЙЛАН

Ерөнхий зүйл

Аудитын нэр: “Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”

Аудитын код: ХЭА-2025/27-21-ШТА-ГА

Аудитын хийх үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2024 оны “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг Монгол Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- А. Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт нь хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэх;
- Б.Хүү,торгуулийн орлого бүрдүүлэлтийг хууль, журамд нийцүүлэн төвлөрүүлсэн эсэх;
- В.Хүү, торгуулийн орлогын зарцуулалт үр дүнтэй эсэх;
- Г.Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй хэрэгжсэн эсэх.

Хамарсан хүрээ:

Аймгийн хэмжээнд хүү, торгуулийн орлого төлөвлөх, бүрдүүлэх, зарцуулах, хяналт хэрэгжүүлдэг төрийн байгууллагуудын чиг үүргийн хэрэгжилт, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, 2023, 2024 онд хүү, торгуулийн орлогыг бүрдүүлсэн байдал, зарцуулалт, хяналт хэрэгжүүлэхтэй холбоотой тайлан мэдээ, дансны хуулга, бусад нотлох баримт, асуулга, лавлагаа авах, судалгаа, тоон мэдээлэл авах, түүвэрлэлт, тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ, харьцуулалт хийх зэрэг аудитын арга зүйг хэрэгжүүлж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсрууллаа.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУС 100, 300, 400, 3000, 4000-д нийцүүлэн боловсруулсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын тулгуур зарчим”, NS6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудит”, Монгол Улсын Ерөнхий аудиторов А/106 дугаар тушаалаар баталсан 2020 оны “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу гүйцэтгэлээ. Монгол Улсын Ерөнхий аудиторов 2021 оны А/69 тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”, 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан батлуулж, аудитын горим сорилыг хэрэгжүүлэв.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, эрхийн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- ✓ Монгол Улсын Үндсэн хууль;
- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- ✓ Нийгмийн даатгалын багц хуулиуд;
- ✓ Татварын багц хуулиуд;
- ✓ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- ✓ Гаалийн ерөнхий хууль;
- ✓ Засгийн газрын тусгай сангийн тухай хууль;
- ✓ Автозамын тухай хууль;
- ✓ Зөрчлийн тухай хууль;
- ✓ Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль;
- ✓ Улсын бүртгэлийн тухай хууль;
- ✓ Иргэний хууль;
- ✓ Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль;
- ✓ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль;
- ✓ Эрүүгийн хууль;
- ✓ Байгаль орчныг хамгаалах тухай хууль;
- ✓ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль;
- ✓ Төрийн аудитын тухай хууль;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- ✓ Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- ✓ Засгийн газрын 2020 оны 107 дугаар тогтоолоор баталсан “Гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журам”;
- ✓ Засгийн газрын 2021 оны 135 дугаар тогтоолоор баталсан “Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журам”;
- ✓ Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар баталсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”;
- ✓ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”;
- ✓ Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- ✓ Хэнтий аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020 оны хуралдааны 28 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “аймагт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажиллах журам”
- ✓ Хэнтий аймгийн ИТХ-ын 2024 оны гуравдугаар хуралдааны 01 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “аймагт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажиллах журам”
- ✓ Бусад холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн актууд.

Үндсэн мэдээлэл:

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2, 23.9.2 дахь хэсэгт “... хүү, торгуулийн орлого” нь аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хот, сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлогод хамаарахаар зохицуулагдсан.

Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан төсвийн орлогын эдийн засгийн ангиллын дагуу татварын бус орлогын нийтлэг татварын бус орлогод хамаарч “хүү, торгуулийн орлого” гэсэн ангиллаар орон нутгийн төсвийн гүйцэтгэлд тайлагнагдаж байна. Төсвийн орлогын ангиллыг 2023, 2024 оноор харьцуулан харуулбал:

Хэнтий аймгийн төсвийн орлогын ангилал

Хүснэгт № 1	2023 он			2024 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь
Татварын орлого	21,469.9	28,105.5	130.9	29,360.0	42,750.4	145.6
Татварын бус орлого	4,511.3	3,308.4	77.3	6,650.2	7,611.7	114.5
Хүү, торгуулийн орлого	2,961.6	1,675.6	56.6	3,000.6	3,438.9	114.6

/Эх сурвалж: ТЕЗ-ийн 2023, 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан/

Хүснэгтээс харахад татварын бус орлогын 45.0-50.0 хувийг хүү, торгуулийн орлого эзэлж байна.

Хүү, торгуулийн орлогын төлөвлөгөө 2023 онд 56.5 хувь, 2024 онд 114.6 хувиар биелсэн байна.

БҮЛЭГ 1. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР НЬ ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ СУДАЛГААНД ҮНДЭСЛЭН БОДИТ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГАД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.

А.1. Торгуулийн орлогыг бодит хэрэгцээ шаардлагад нийцүүлэлгүй авто замын сан болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулахаар төлөвлөж байна.

1.1 Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3¹ т заасан төсвийн орлогын нэг хэсэг болох торгуулийн орлогыг 2023 онд 745.0 сая төгрөгөөр төсвийн төсөл хүргүүлж Сангийн яам 2,181.7 сая төгрөгөөр, 2024 онд 1,100.0 сая төгрөгөөр төсвийн төсөл хүргүүлж 1,576.2 сая төгрөгөөр тус тус хянасан байна.

Сангийн яамнаас хянаж ирүүлсэн орлогын суурийг аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хурлаар 2023 онд 2,961.6 сая, 2024 онд 3,000.6 сая төгрөг болгон баталсан байна.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-т “хяналт шалгалтын байгууллага улсын болон орон нутгийн төсөвт орлого оруулах үүрэг хүлээхгүй” гэж заасныг үндэслэн зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтантай байгууллагууд нь торгуулийн орлогыг төлөвлөдөггүй байна.

Зөрчлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4.1-т “Энэ хуулийн тусгай ангид заасан хэмжээгээр шүүх, эрх бүхий албан тушаалтнаас мөнгөн төлбөр оногдуулахыг торгох шийтгэл гэнэ” гэж заасны дагуу торгуулийн орлогыг орон нутгийн төсвийн оролгод төвлөрүүлэхээр Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2-т “...хүү, торгуулийн орлого” гэж заажээ.

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасан зөрчлүүдэд оногдуулсан торгох шийтгэлээс төсөвт төвлөрүүлсэн орлогын 40-өөс доошгүй хувийг дараагийн төсвийн жилд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулахаар, Авто замын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-т “нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаархи хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль”-ийг замын санд тус тус зарцуулахаар заасны дагуу торгуулийн орлогыг жил бүр төлөвлөж байна.

¹ Татварын бус орлого нь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр, төрийн болон орон нутгийн өмчийг түрээслэсний орлого, торгуулийн орлого, төсвийн байгууллагын туслах үйл ажиллагааны орлого, Засгийн газрын зээллэг, тусламж болон хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2² дахь заалттай нийцүүлэн олон нутгийн торгуулийн орлогыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, замын сангийн ажилд тус тус зарцуулахаар төлөвлөж байна.

А.2. Торгуулийн орлогыг судалгаанд үндэслэн төлөвлөхгүй байна.

2.1 Хэнтий аймгийн зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллагуудаас 2023 онд 32,876 зөрчилд 1,447.5 сая төгрөг, 2024 онд 42,114 зөрчилд 1,545.8 сая төгрөгийн торгууль оногдуулсан байна.

Орон нутгийн төсвийн орлогод 2023 онд 1,675.6 сая төгрөг, 2024 онд 3,438.9 сая төгрөгийн торгуулийн орлогыг төвлөрүүлснээс 2023 онд 1,282.1 сая төгрөгийг, 2024 онд 1,202.7 сая төгрөгийг тайлант онд Хэнтий аймгийн эрх бүхий байгууллагын оногдуулсан торгуулийн орлого байна.

Нийт орлогын үлдсэн хэсэг нь өмнөх оны торгууль болон ТЕГ-ын том татвар төлөгчтэй харилцах газраас хяналт шалгалтаар тогтоосон торгууль төрийн санд төвлөрсөн орлого байна.

Эрх бүхий байгууллагуудын оногдуулсан торгуулийн дүнгийн 69.7-76.9 хувийг аймгийн Цагдаагийн газар, 12.3 –16.4 хувийг Татварын газар, 7.3-9.4 хувийг Байгаль орчны газар тус тус оногдуулсан байна.

Цагдаагийн газрын 2023-2024 онд оногдуулсан торгуулийг зөрчлийн ангиллаар нь өндөр дүнтэйг түүвэрлэн авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- 14.7.1 1."Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй /жолоодлогын дадлага хийхээс бусад тохиолдолд/, эсхүл тээврийн хэрэгсэл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн тээврийн хэрэгсэл жолоодсон бол хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно" гэсэн заалтаар 323.8 сая төгрөг,

- 14.7.3.1 3.2."согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нэг жилийн хугацаагаар хасаж хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно" гэсэн заалтаар 232.4 сая төгрөг,

- 14.7.20 "Замын хөдөлгөөний дүрэмд зааснаар тээврийн хэрэгслийн жолооч, эсхүл зорчигч хамгаалах бүс хэрэглээгүй бол хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно" гэсэн заалтаар 273.4 сая төгрөгийн торгуулийг оногдуулсан байна.

Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс нь эрх бүхий байгууллагуудын оногдуулсан торгуулийн дүн, түүний хэрэгжилтийн талаар судалгаа, мэдээлэлгүй, Сангийн яаманд хүргүүлсэн төсвийн төслийн хүү торгуулийн дүнг 2023, 2024 онуудад нийт 4,112.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож баталсан байна.

Торгуулийн орлогын төлөвлөлт

Хүснэгт № 2

/сая төгрөг/

№	Он	СЯ-нд хүрүүлсэн	СЯ-аас хянасан	ИТХ-аар баталсан	Зөрүү
1	2023	750.0	2,181.7	2,961.6	2,211.6
2	2024	1,100.0	1,576.2	3000.6	1,900.6
Нийт					4,112.2

Торгуулийн орлогын төлөвлөгөө биелэлтийг сумдаар авч үзвэл дараах байдалтай байна.

Орон нутгийн хэмжээнд хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт

Хүснэгт №3

/сая төгрөг/

№	Сумдын нэр	2022 он	2023 он		2024 он
		гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө
1	Галшар	6.8	3.5	1.5	1.5
2	Баянхутаг	3.7	8.0	2.4	9.8
3	Баянмөнх	17.8	9.5	10.4	19.0

² 6.2.2.жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх;

4	Дархан	6.1	4.0	4.3	12.6
5	Дэлгэрхаан	8.6	7.0	12.7	11.5
6	Жаргалтхаан	71.0	75.0	61.9	103.4
7	Цэнхэрмандал	133.3	160.0	199.3	240.0
8	Өмнөдэлгэр	8.5	9.0	19.5	12.6
9	Батширээт	7.8	6.6	6.0	14.0
10	Биндэр	49.2	13.0	7.5	46.0
11	Баян-Адарга	8.2	7.0	3.4	12.0
12	Дадал	1.2	6.2	4.5	28.0
13	Норовлин	8.6	12.0	4.2	15.4
14	Батноров	9.8	9.0	4.8	11.2
15	Баян-Овоо	4.6	4.5	1.6	6.3
16	Мөрөн	13.7	12.0	18.4	22.4
17	Хэрлэн сум		347.5	329.7	469.0
18	Гурванбаян	381.9	-	0.3	3.0
19	Хэрлэнбаян-Улаан	1.6	2.0	2.2	3.6
20	Өлзийт	0.8	3.2	0.3	2.0
21	Бор-Өндөр	2.4	135.7	63.6	168.0
22	Бэрх	140.3	15.0	29.5	28.0
23	Аймгийн төв	33.9	2,111.9	887.7	1,761.3
Дүн		1,455.8	2,961.6	1,675.6	3,000.6

/Эх сурвалж: Хэнтий аймгийн CTCX-ийн орлогын мэдээ/

Дээрх хүснэгтээс харвал хүү, торгуулийн орлогын гүйцэтгэл 2022 онд 1,455.8 сая төгрөг байсныг 2023 онд 2,961.6 сая төгрөгөөр, 2023 оны гүйцэтгэл 1,675.6 сая төгрөг байсныг 2024 онд 3,000.6 сая төгрөгөөр баталсан нь өмнөх оны гүйцэтгэлд үндэслээгүйг харуулж байна.

Сумдын торгуулийн орлогын ялгаатай байдал нь улсын чанартай автозамын сүлжээ, хүн амын тоо, авч хэрэгжүүлсэн хяналт шалгалтын арга хэмжээ зэргээс шалтгаалж байна.

Аймаг, сумын ИТХ-ын хуралдаанаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг 2023 онд 213.0 сая төгрөгөөр, 2024 онд 238.0 сая төгрөгөөр төлөвлөжээ. Үүнээс сумдын ИТХ-аас гэмт хэргийн зардалд 177.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

А.3. Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлттэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг сайжруулах шаардлагатай байна

3.1 Хууль эрх зүйн зохицуулалттай холбоотой дараах асуудлыг анхаарах шаардлагатай байна. Үүнд:

- Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь Зөрчлийн тухай хуулийн 15.24 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг хэрэгжүүлэн 2023 онд 323 иргэний 6.5 сая төгрөгөөр, 2024 онд 178 иргэнийг 3.6 сая төгрөгөөр тус тус торгох шийтгэлийг оногдуулсан байна. Аудитын явцад шалгагдагч тал дээрх хуулийн заалтыг хэрэгжүүлэхэд их хэмжээний бичиг хэргийн зардал гаргах, эрх бүхий албан тушаалтны ажлын ачаалал нэмэгдэх, цаг хугацааг их зарцуулах зэрэг хүндрэлтэй нөхцөл байдал байгаа талаар тайлбар өгсөн болно. Мөн иргэний үнэмлэхээ тогтоосон хугацаанд шинээр авах үүргээ биелүүлээгүй насанд хүрээгүй иргэнийг 20 нэгжээр торгохын тулд эцэг эх, асран хамгаалагчийн хамт байлцуулах шаардлагатай нь сумдын иргэдэд замын зардал болон цаг хугацааны хувьд хүндрэлтэй байдаг талаар дурьдсан болно.
- Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан, эсхүл уг төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй, биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох газарт тайлагнаагүй бол хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан нь уул уурхайн компаниуд дээрх төлөвлөгөөг батлуулалгүй үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлж байна.
- Зөрчлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.17.3-т “Цэргийн бүртгэлийн журам зөрчсөн, эсхүл дайчилгаатай сургууль, цугларалт, цэрэг татлагаас зайлсхийсэн цэргийн үүрэгтэн, цэргийн насны иргэнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний

төгрөгөөр торгоно” гэсэн нь цэргийн насны иргэд цэрэг татлагад оролцолгүйгээр торгуулиа төлж цэргийн алба хаах иргэний үүргээ биелүүлэхгүй байх шалтгаан болж байна.

Б. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАНУУД ОНОГДУУЛСАН ТОРГУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ АЖИЛЛААГҮЙГЭЭС 2023-2024 ОНД 508.4 САЯ ТӨГРӨГИЙН ОРЛОГЫГ ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

Б.1. Эрх бүхий албан тушаалтанууд орон нутгийн төсөвт төвлөрүүлэх 508.4 сая төгрөгийн торгуулийн орлогыг барагдуулаагүй, 50.4 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт шилжүүлсэн байна.

1.1 Хэнтий аймгийн хэмжээнд 2023,2024 онуудад 12 байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд 2,941.8 сая төгрөгийн торгууль оногдуулж, 2,233.7 төгрөгийг барагдуулж, 708.1 сая төгрөгийн торгуулийг аудит хамрагдсан ондуудад биелэлтийг хангуулаагүй байна. Үүнд:

- 2023 онд 1,446.7 сая төгрөгийн торгууль оногдуулж, 1,190.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт, 9.6 сая төгрөгийн улсын төсвийн дансанд төвлөрүүлж, 246.8 сая төгрөгийн торгуулийн биелэлтийг хангуулаагүй.
- 2024 онд 1,495.1 сая төгрөгийн торгууль оногдуулж, орон нутгийн төсөвт 993.0 сая төгрөг, улсын төсөвт 40.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 461.3 сая төгрөгийн торгуулийн хэрэгжилтийг хангуулаагүй байна.

Хэнтий аймгийн эрх бүхий байгууллагын торгуулийн оногдуулалт, тайлант оны төвлөрүүлэлт
Хүснэгт № 4 /сая төгрөг/

№	Байгууллагын нэр	2023 он			2024 он		
		Оногдуулсан	Төвлөрсөн	Зөрүү	Оногдуулсан	Төвлөрсөн	Зөрүү
1	Цагдаагийн газар	1,118.9	897.1	221.8	1,040.9	655.1	385.8
2	Улсын бүртгэлийн хэлтэс	14.5	14.5	-	7.5	7.5	-
3	Аймгийн ЗДТГ	0.6	0.6	-	5.6	5.6	-
4	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	0.6	0.0	0.6	0.0	0.0	-
5	Эрүүл мэндийн газар	0.6	0.6	-	4.3	4.3	-
6	Хүнс, хөдөө аж ахуйн газар	5.8	5.8	-	3.0	3.0	-
7	Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	0.2	0.2	-	0.0	0.0	-
8	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар	3.0	3.0	-	33.5	33.5	-
9	Аймгийн татварын газар	168.1	158.3	9.8	249.5	197.3	52.2
10	Байгаль орчны газар	107.0	99.8	7.2	142.3	126.7	15.6
11	Хэнтий аймаг дахь Монгол банкны салбар	4.0	4.0	-	0.0	0.0	0.0
12	Онцгой байдлын газар	23.4	16.0	7.4	8.5	0.8	7.7
	ДҮН	1,446.7	1,199.9	246.8	1,495.1	1,033.8	461.3

Хэнтий аймгийн хүү торгуулийн орлогын ногдуулалтын 48.3-51.6 хувийг Цагдаагийн газрын цахим буюу бэлэн бус торгууль эзэлж байгаа бөгөөд 2025 оны 7 дугаар сарын 04- ний өдрийн байдлаар 288.7 сая төгрөг төлөгдөөгүй байна.

Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарууд 2023 онд 9.6 сая төгрөг, 2024 онд 40.8 сая төгрөг, нийт 50.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7 “Аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ” 23.7.2-т “...хүү, торгуулийн орлого” гэж заасныг зөрчсөн байна.

1.2 Хэнтий аймгийн хэмжээнд Зөрчлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-т заасан эрх бүхий албан тушаалтнуудын оногдуулсан торгуулийн шийтгэлийн хуудсыг Засгийн газрын 2021 оны 135, 2024 оны 38 дугаар тогтоолуудаар баталсан маягтын дагуу аймгийн Прокурорын газар хянаж байна.

Харин цахим хэлбэрээр торгосон шийтгэвэрт прокурорын хяналтыг хэрэгжүүлэх асуудлыг эрхзүйн актаар зохицуулаагүй байна.

1.3 Хэнтий аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд 1,675.6 сая төгрөг, 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд 3,438.9 сая төгрөгийн хүү, торгуулийн орлого төвлөрч тайлагнасныг санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажуулсан.

Зарим байгууллагуудын улсын төсвийн дансанд төвлөрүүлсэн 50.4 сая төгрөгийн торгуулийн орлогыг тайланд тусгаагүй, тооцоо нийлээгүй байна.

Б.2. Замын сан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг хуулийн дагуу бүрдүүлж байгаа эсэх нь тодорхойгүй байна.

2.1 Аймаг, сумын ИТХ-ын хуралдаанаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг 2023 онд 213.0 сая төгрөгөөр, Орон нутгийн замын санг 1,860.0 сая төгрөгөөр баталсан. 2024 онд Аймаг, сумдын ИТХ-ын хуралдаанаар орон нутгийн 2024 оны төсвийн тодотгол батлах тухай тогтоолуудаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг 238.0 сая төгрөгөөр, орон нутгийн замын санг 1,542.2 сая төгрөгөөр баталж, хуваарилах бүрэн эрхээ хэрэгжүүлсэн байна.

Аймаг болон сумын төсвийн орлогод 2023 онд 1,675.6 сая төгрөг, 2024 онд 3,438.9 сая төгрөгийн торгуулийн орлогыг төвлөрүүлсэн бөгөөд үүнээс хуульд заасан торгох шийтгэлийн дүнгээс авч үзвэл 2024 онд 297.6 сая төгрөгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд төлөвлөх боломжтой байсан боловч 238.0 сая төгрөгөөр баталсан нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасан хувь хэмжээг баримтлаагүй болохыг харуулж байна

2.2 Торгуулийн орлогыг зөрчлийн ангилалаар бус нэгдсэн дансанд төвлөрүүлж байгаа болон эрх бүхий байгууллагуудаас оногдуулсан шийтгэлийн биелэлтийн нэгдсэн мэдээллийг бүрэн нэгтгэж аваагүйгээс шалтгаалж ГХУСАЗСЗ-ийн зардлын эх үүсвэрт хамаарах зөрчлөөс орон нутгийн төсөвт төвлөрсөн мөнгөн дүнг тооцох боломжгүй байна.

Автозамын тухай хуульд заасан орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаархи хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгуулийн орлогыг тусгай дансанд төвлөрүүлэх замаар дээрх тодорхойгүй байдлыг шийдвэрлэх боломжтой гэж үзлээ.

2.3 Торгууль ногдуулах эрх бүхий албан тушаалтнуудын гаргасан шийдвэрийн хэрэгжилт, төвлөрүүлсэн орлогын үзүүлэлтийг албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэхэд харгалзан үздэггүй байна.

Эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрийн хэрэгжилтийг тогтмол үнэлэх, гүйцэтгэлийн тайланд тусгах, үнэлгээнд нөлөөлүүлэх боломжийг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нэвтрүүлснээр үнэлгээний ил тод байдал, хариуцлага сайжирч, орлого бүрдүүлэлт нэмэгдэх боломжтой байна.

В. АЙМГИЙН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 25 АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЖЭЭГҮЙ, ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСАГДААГҮЙ 8 АРГА ХЭМЖЭЭНД 40.8 САЯ ТӨГРӨГИЙГ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

В.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд батлагдсан төсвийн 21.9 хувийг төлөвлөөгүй арга хэмжээнд зориулалт бусаар зарцуулсан байна.

Хэнтий аймагт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг Аймгийн ГХУСАЗСЗ-ийн 1 дүгээр тогтоолоор 2023 онд 51 арга хэмжээг 114.8 сая төгрөгөөр, 2024 онд 28 арга хэмжээг 157.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж баталсан байна. Энэ нь өмнөх оноос 36.7 хувиар өссөн байна.

Хүснэгт № 5

/сая төгрөг/

Он	Төлөвлөгөө		Хэрэгжилт		Хэрэгжээгүй	
	арга хэмжээ	санхүүжилт	арга хэмжээ	санхүүжилт	арга хэмжээ	санхүүжилт
2023 он	51	114.8	34	87.7	17	12.0
2024 он	28	157.0	20	139.0	8	18.0
ДҮН	79	271.8	54	226.7	25	30.0

Төлөвлөсөн арга хэмжээнээс 68.4 хувь буюу 54 арга хэмжээг 226.7 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн бол 31.6 хувь буюу 25 арга хэмжээ хэрэгжээгүй байна. ГХУСАЗСЗ-ийн баталсан төлөвлөгөөнд тусгагдаагүй 8 арга хэмжээ зохион байгуулж 40.8 сая төгрөгийг зарцуулсан нь нийт зардлын 15 хувийг эзэлж байна. Үүнд:

Төлөвлөөгүй арга хэмжээг санхүүжүүлсэн дүн

Хүснэгт № 6

/сая төгрөгөөр/

Д/д	Арга хэмжээний нэр	Зардлын дүн	
		2023 он	2024 он
1	ГХУСАЗСЗ-ийн гишүүдийг урамшуулах.	1.9	4.5
2	ГХУСАЗСЗ-ийн хуралдааныг зохион байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж худалдаж авах	4.7	
3	Сумын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нарыг чадавхижуулах сургалт, туршлага судлах аялалын зардал	5.5	
4	Өсвөр насны хүүхдүүдийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх яиглэлээр мэдлэг олгох, гэмт хэргийн хохирол, хор уршгийг таниулах зорилго бүхий 15 ангит цуврал контент бүтээх	15.0	
5	Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хуралдааныг улирал бүр зохион байгуулах		3.2
6	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хамрах хүрээг өргөтгөх, хууль тогтоомж сурталчлах зорилгоор ГХУСАЗСЗ-ийн даргын нэрэмжит шатрын тэмцээн зохион байгуулах		1.0
7	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан таниулах, авлига албан тушаалын хэрэг, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах		3.0
8	Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын зүүн бүсийн зөвлөгөөн зохион байгуулах		2.0
ДҮН		27.1	13.7

Энэ нь урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг гэмт хэргийн нөхцөл байдалд судалгаа, үнэлгээ хийж үндэслэлтэй боловсруулж, биелэлтэд хяналт тавих, биелэлтийг хангуулах ажлыг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд 2023, 2024 онуудад нийт 271.5 сая төгрөг зарцуулсан байна.

Санхүүжилтийн зарцуулалт, байгууллагаар

Хүснэгт № 7

/сая төгрөг/

№	Байгууллагын нэр	2023 он	2024 он	Нийт дүн	Дүн эздэх хувь
1	Аймгийн ИТХ	70.2	32.5	102.7	38%
2	Цагдаагийн газар	31.5	44.3	75.8	28%
3	Гэр бүл, Хүүхэд, залуучуудын газар	2.0	12.5	14.5	5%
4	Шүүхийн шинжилгээний алба	4.0	5.0	9.0	3%
5	Шүүхийн тамгын газар		6.5	6.5	2%
6	Прокурорын газар		2.0	2.0	1%
7	Онцгой байдлын газар	5.0	5.0	10.0	4%

8	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	2.0	-	2.0	1%
9	Орон нутгийг судлах музей		3.0	3.0	1%
10	Сумдын салбар зөвлөлд		46.0	46.0	17%
	ДҮН	114.7	156.8	271.5	100%

Дээрх хүснэгтээс дүгнэж үзвэл нийт зардлын 38 хувийг аймгийн ИТХ, 28 хувийг цагдаагийн газар, 17 хувийг сумдын салбар зөвлөлд хуваарилж олгосон санхүүжилт, 17 хувийг гэр бүл, хүүхэд, залуучуудын газар, шүүхийн тамгын газар, прокурорын газар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар зэрэг гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд олгосон санхүүгийн дэмжлэг эзэлж байна.

Зардлын гүйцэтгэлийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлд заасан дараах чиглэлүүдэд зарцуулжээ.

Зардлын ангилал

Хүснэгт № 8

/сая төгрөг/

Зардлын төрөл	Амгийн ГХУСЗ	Сумдын ГХУСЗ	Нийт	Дүнд эзлэх хувь
46.3.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг аймаг, нийслэлийн батлагдсан төсөв дээр нь нэмж олгох замаар төвлөрүүлж, сум, дүүргийн Салбар зөвлөл, гэмт хэргийн нөхцөл байдал, цаашдын төлөвийг харгалзан хуваарилж, зарцуулна.	47.6	-	47.6	11%
46.5.1.гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хууль сахиулах болон төрийн бус байгууллага, иргэдээс иргэд, байгууллагын дунд зохион байгуулж байгаа сургалт, сурталчилгааны ажлын зардлыг санхүүжүүлэх;	104.3	51.1	155.4	35%
46.5.2.энэ хуулийн 34 дүгээр зүйлд зааснаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон хүн, хуулийн этгээдийг шагнаж, урамшуулах;	16.2	-	16.2	4%
46.5.3.энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүргээ биелүүлж яваад эрүүл мэндээрээ хохирсон буюу амь насаа алдсан тохиолдолд түүнд болон ар гэрт нь олгох тэтгэвэр, тэтгэмжийн зөрүү, зардал, нөхөн төлбөрийг төлөх;	-	-	-	-
46.5.4.гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд болон шүүхийн шинжилгээний байгууллагаас хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн зардлыг санхүүжүүлэх;	103.4	111.0	214.4	48%
46.5.5.гэмт хэрэг, зөрчил үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа болон үйлдсэн тухай мэдээллийг иргэдээс авах төлбөрийн зардлыг санхүүжүүлэх;	-	-	-	-
46.5.6.гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу үнэлгээ, судалгаа хийх, тэдгээрийг хэлэлцүүлэх, хуульд заасан дүрэм, журам, заавар боловсруулах;	-	-	-	-
46.5.7.тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга, ажиллагааны талаарх судалгааны ажилд зарцуулах;	-	-	-	-
46.5.8.олон нийтийн цагдаагийн урамшуулал, эрүүл мэндийн даатгалын зардлыг санхүүжүүлэх;	-	-	-	-
46.5.9.энэ хуулийн 14.2-т заасан Зохицуулах зөвлөлийн орон тооны ажлын албаны үйл ажиллагаа, албан хаагчийн цалин хөлс, Салбар зөвлөлийн орон тооны нарийн бичгийн даргын цалин хөлсний зардлыг санхүүжүүлэх;	-	7.8	7.8	2%
46.5.10.авто замын тэмдэг, тэмдэглэлийг шинээр байршуулах, шинэчлэх, засварлах.	-	7.0	7.0	2%

46.5.11.хууль тогтоомжид заасан бусад.	-	-	-	-
ДҮН	271.5	177.0	448.5	100%

Нийт зардлын дүнд гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд 48 хувь, сургалт, сурталчилгааны ажилд 35 хувь, сумдын салбар зөвлөлд 11 хувийг хуваарилж зарцуулсан байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46.5.6, 46.5.7, 46.5.8-д заасан судалгаа хийх, дүрэм журам заавар боловсруулах, олон нийтийн цагдаагийн урамшуулал зэрэг зардлуудад төсөв зарцуулаагүй байна.

ГХУСАЗСЗ-ийн нарийн бичгийн даргын орон тоонд ажилладаг албан хаагчийн цалинг дээрх хуулийн 46.5.9 -д заасны дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас төлөвлөж зарцуулалгүй орон нутгийн төсвөөс олгосон байна.

ГХУСЗ-ын зарцуулалтад аудитын горим, сорил хэрэгжүүлэхэд нийт зардлын 6.8 хувийг буюу 18.6 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрлээ. Үүнд:

- *Иргэний зөвлөлийн урамшуулалд 8.5 сая төгрөг*
- *Цагаатгалын урамшуулалд 1.4 сая төгрөг,*
- *Шүүхийн үйл ажиллагааг иргэдэд түргэн шуурхай хүргэхэд зориулж 6.5 сая төгрөгийн киоск машин авах санхүүжилт олгосон,*
- *УИХ-ын сонгуулийн сургалт, бага хуралд оролцох томилолтын зардалд 1.1 сая төгрөг,*
- *Шатарын тэмцээн зохион байгуулахад 1.0 сая төгрөгийг зарцуулжээ.*

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулсан төсвийг хүн амын тоо, гэмт хэрэг зөрчлийн тоонд харцуулсан судалгаа

Хүснэгт № 8

/мянган төгрөг/

Он	Хүн амын тоо	Гэмт хэрэг зөрчлийн		ГХУС зардал		Нэг хүнд ногдох зардал
		Тоо	Өсөлтийн хувь	Дүн	Өсөлтийн хувь	
2023 он	78,877	78,877	102%	211,774.0	112%	2.7
2024 он	79,251	42,616	133%	236,895.0	112%	3.0
Нийт дүн	79,064	105,964		448,669.0		2.8

Аудитад хамрах хугацаанд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулж буй төсөв 12 хувь, гэмт хэрэг, зөрчлийн тоо 33 хувь тус тус өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь үйл ажиллагааны төлөвлөгөөг тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга, ажиллагааны талаарх судалгаанд үндэслээгүй, төлөвлөсөн арга хэмжээ нь оновчгүй байгааг харуулж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулахад зориулж баталсан төсвийг хүн амын тоонд харьцуулахад дунджаар 2.8 мянган төгрөг байгаа нь иргэд, олон нийтэд хүртээмж хангалтгүй, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө бага байна.

Сумдаар авч үзвэл нэг хүнд дунджаар 481.5-1,514 төгрөг ногдож байна. Энэ нь тус зардлыг бага байгааг харуулж байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулсан зардлыг хүн амын тоонд харьцуулсан судалгаа

Хүснэгт № 9

/мянган төгрөг/

Хэнтий	2023 он				2024 он			
	Хүн амын тоо	Сумын бүрдүүлсэн Хүү, торгуулийн орлого	Сумын ГХУСЗ	Нэг хүнд ногдох ГХУСЗ-ын санхүүжилт /төгрөг/	Хүн амын тоо	Сумын бүрдүүлсэн Хүү, торгуулийн орлого	Сумын ГХУСЗ	Нэг хүнд ногдох ГХУСЗ-ын санхүүжилт /төгрөг/
Хэрлэн	24,370	329,948	27,990.1	1,149	24,764	520,612.00	31,974	1291.1
Батноров	5,689	34,240	1,949.6	343	5,731	45,710.83	9,890	1725.6
Батширээт	2,314	6,010	-	-	2,297	3,296.00	5,000	2176.8

Баян-Адарга	2,586	3,420	-	-	2,613	3,730.00	2,700	1033.3
Баянмөнх	1,768	10,370	-	-	1,763	4,780.00	2,000	1134.4
Баян-Овоо	1,995	1,605	-	-	1,934	3,715.72	2,000	1034.1
Баянхутаг	2,432	2,350	-	-	2,379	4,978.00	2,000	840.7
Биндэр	4,172	7,482	-	-	4,154	21,702.50	2,000	481.5
Галшир	2,195	1,546	-	-	2,140	2,936.00	2,000	934.6
Дадал	3,128	4,520	-	-	3,143	15,985.34	3,000	954.5
Дархан	2,101	4,278	-	-	2,100	3,352.00	2,000	952.4
Дэлгэрхаан	2,434	14,935	-	-	2,398	7,860.00	2,000	834.0
Жаргалтхаан	2,194	61,930	17,090.7	7,790	2,174	59,596.00	8,948	4115.7
Мөрөн	1,873	18,387	-	-	1,845	43,698.00	5,000	2710.0
Норовлин	2,919	4,239	-	-	2,951	9,531.00	3,730	1264.0
Өмнөдэлгэр	5,841	19,780	-	-	5,868	20,243.09	6,000	1022.5
Цэнхэрмандал	2,056	199,290	-	-	2,030	255,971.35	2,000	985.2
Бор-Өндөр	8,810	63,576	49,999.3	5,675	8,967	77,096.68	33,698	3758.0
Нийт дүн	78,877	787,906	97,029.7	14,956	79,251	1,104,795	125,939	27,248
Дундаж				830.90				1,513.8

В.2. Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг ил тод мэдээлж байна.

Аймгийн ИТХ-ын дэргэдэх ГХУСАСЗ-ийн ажлын албаны санхүүжилтийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд тусган баталж, зарцуулж байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын зарцуулалтыг аймгийн ИТХ-ын шилэн дансны цахим мэдээллийн системд үндсэн үйл ажиллагаатай хамт мэдээлж байна.

Шилэн дансны мэдээллийн системд 2024 онд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 157.0 сая төгрөг, зарлагын 69.0 сая төгрөгийн 21 мөнгөн гүйлгээг бүрэн мэдээлсэн байна. Харин 2023 онд орлого, зарлагын 128.6 сая төгрөгийн мөнгөн гүйлгээ, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг мэдээлээгүй зөрчилд санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж хүргүүлсэн байна.

ГХУСАСЗ-өөс ИТХ-ын пэйж хуудас болон Хорин хоёр ньюс, Импакт медиа групп ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан “Монголын мэдээ” пэйж хуудсаар дамжуулан зөвлөлийн үйл ажиллагаа болон гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг олон нийтэд мэдээлж байна. Тухайлбал:

- Өсвөр насны хүүхдүүдийн эсрэг үйлдэгдэх гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хорт зуршил, сэтгэл гутрал зэрэг 10 ангит цуврал контентийг 15.0 сая төгрөгөөр бэлтгэж сумдын салбар зөвлөл, гэмт хэргийн хуралдаан, пэйж хуудсаар дамжуулдан олон нийтэд мэдээлсэн;
- Ярьж буй хууль, “Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй”, “Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” арга хэмжээний хүрээнд нийтийн цахим сүлжээгээр ухуулга нөлөөллийн сэрэмжлүүлэх видео контент 4, нөлөөллийн үгтэй зураг 65, арга хэмжээний шууд дамжуулалт 2, зорилтот бичлэг 21, мэдээ 16 зэрэг нийт 171 мэдээ, мэдээлэл, контентыг инстаграмм, твиттер, фейсбүүк платформд байршуулан ажилласан нь 16 788 824 цахим хэрэглэгчдэд хүрч, 159 209 хүн бусадтай хуваалцаж, 295 757 хүнд таалагдсан үр дүнтэй ажилласан байна.

Иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөл зэрэг оролцогч талууд 2023, 2024 онд ГХУСЗ-ын гүйцэтгэлтэй холбоотой ил тод байдалд үнэлгээ өгч, санал хүргүүлээгүй байна.

Г. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТЭД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

Г.1. Хүү, торгуулийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бий болгож ногдуулалт, бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

1.1 Аудитын явцад байгууллага хооронд мэдээлэл солилцох нэгдсэн сан бий болсон эсэхийг авч үзэхэд эрх бүхий байгууллагуудын салбарын хуулиудад дараах заалтуудыг тусгасан байна. Тухайлбал:

- Цагдаагийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.7-д “цагдаагийн байгууллага өөрийн өдөр тутмын үйл ажиллагааны шуурхай, үр дүнтэй байдлыг хангах зорилгоор өөрийн дотоод хэрэгцээнд бусад төрлийн мэдээллийн санг байгуулж болно”
- Татварын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т “татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд дараах мэдээлэл хамаарна: татвар, алданги, торгуулийн бүртгэл”

1.2 Хэнтий аймгийн хэмжээнд авто тээврийн төв, “Хур-Дан” үйлчилгээний өөртөө үйлчлэх киоск төхөөрөмж, сумын төвүүдийн иргэдэд үйлчлэх төвийн киоск төхөөрөмжөөр торгуулийн орлогыг төлөх нөхцлийг хангасан байна. Мөн И-Монголия, банкуудын цахим программууд, авто тээврийн хэрэгслийн мэдээллийн цахим программ зэргийг ашиглан торгуулийг цахимаар төлөх боломж бүрдсэн байна.

1.3 Татварын газар, Цагдаагийн газрууд нь нэгдсэн мэдээллийн системтэй бөгөөд уг системээр шийтгэврийн хуудасны зарцуулалт, хэрэгжилтийг бүртгэж хяналтыг хийж, торгуулийг хуулийн хугацаанд төвлөрүүлэх, шат дараалсан арга хэмжээг авч ажиллах боломжтой байна.

Бусад байгууллагын хувьд цахим хяналтын системгүйгээс тогтоосон хугацаанд хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих боломжгүй байна.

Г.2. Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлтэд хяналт хэрэгжүүлээгүй байна.

2.1 Эрх бүхий албан тушаалтны оногдуулсан шийтгэлийг заасан хугацаанд биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдийг шүүхэд шилжүүлж албадан гүйцэтгүүлэх талаар дараах арга хэмжээг авчээ. Үүнд:

- 2023 онд Цагдаагийн газар 78 иргэнд 19.6 сая төгрөг, Байгаль орчны газар 8 иргэн, аж ахуйн нэгжид 5.1 сая төгрөгийн торгуулийг шүүхийн шийдвэрийн дагуу ШШГГ-т шилжүүлсэн байна.
- 2024 онд Цагдаагийн газар 75 иргэнд 28.4 сая төгрөг, Байгаль орчны газар 9 иргэн, ААН-н 23.0 сая төгрөгийн торгуулийг Шүүхийн шийдвэрийн дагуу ШШГГ-т шилжүүлж хэрэгжилтийг хангуулж ажилласан байна.

Эрх бүхий байгууллагаас оногдуулсан торгуулийн орлого хуульд заасан хугацаанд хэрэгжихгүй байна. Тухайлбал:

Цагдаагийн газар нь 139 шийтгэлийн хуудсаар оногдуулсан 32.9 сая төгрөгийн торгууль 45-591 хоног хугацаа хэтэрч хэрэгжсэн нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалт, МУ-ын ЗГ-ын 2021 оны 135 тогтоолоор баталсан “Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журам”-ын 2.6, 5.6-д заасныг хэрэгжүүлээгүй, Улсын ерөнхий прокурор, хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны А/42, А/71 дугаар хамтарсан тушаалаар баталсан эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцох, хугацаа, аргачлалын 2.2³-т заасныг хэрэгжүүлээгүй, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын “Шийтгэлийн хуудас болон тооцоот маягтаар хангах, хадгалах, олгох, зарцуулах, тооцох, бүртгэх”-ийн 812.7.1. “Шийтгэлийн хуудас, тооцоот маягтын хадгалалт, бүртгэл, зарцуулалт, шийтгэлийн орлогод байгууллагын дарга байнгын хяналт тавьж ажиллана” гэснийг зөрчсөн байна.

2.2 ГХУСАЗСЗ-өөс 2023, 2024 онд төлөвлөгөөний хэрэгжилт, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авах арга хэмжээний талаар улирал бүр хэлэлцэж, санхүүжилтийн зарцуулалтын тайланг тухай бүр холбогдох байгууллагаас авч нэгтгэн, хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлж ажилладаг байна.

³ 2.2.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацаанд биелүүлээгүй тохиолдолд оногдуулсан торгох шийтгэлийн хэмжээг хугацаа хэтрүүлсэн сар бүр 10 хувиар нэмэгдүүлэн тооцно. Шийтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлэн тооцох нийт хугацаа 5 сараас, нийт хувь хэмжээ нь торгох шийтгэлийн 50 хувиас хэтрэхгүй байна.

Төрийн аудитын газраас ИТХ-ын 2023, 2024 оны санхүүгийн тайлангийн аудит хийхэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын шилэн дансанд байршуулаагүй зөрчил илэрсэн байна.

Аймгийн ИТХ-ын дэргэдэх иргэний зөвлөлөөс Цагдаагийн газартай хамтран зохион байгуулж буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг санхүүжүүлж буй зардлын зарцуулалтад улирал бүр хяналт хийж, салбар зөвлөлд танилцуулж ажилладаг байна.

2.3 Орлого төвлөрүүлэгч зарим байгууллага торгуулийн орлогод дотоод хяналт хэрэгжүүлээгүй, арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Шийтгэл, торгуулийн орлогыг тухайн шийдвэрийг ногдуулсан эрх бүхий албан тушаалтан бүрэн хариуцаж зөрчлийн биелэлтийн хуудсыг хэрэг бүртгэлд хавсаргаж, удирдах албан тушаалтан тухай бүр хяналтыг хэрэгжүүлдэг байна. Зарим байгууллагууд хяналт хэрэгжүүлдэггүйгээс торгуулийг төлөөгүй, шүүхэд шилжүүлээгүй байна.

2023 онд Байгаль орчны газар 5.9 сая, Онцгой байдлын газар 7.4 сая, 2024 онд Байгаль орчны газар 4.1 сая, Онцгой байдлын газар 6.7 сая төгрөг, нийт 24.1 сая төгрөгийн торгуулийг хариуцагчаар төлүүлэх шат дараалсан арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Цагдаагийн газрын цахим буюу бэлэн бусаар оногдуулсан торгууль 2025 оны 7 дугаар сарын 04-ний байдлаар 2023 онд оногдуулсан торгуулиас 4,794 зөрчлийн 113.6 сая төгрөг, 2024 онд оногдуулсан торгуулиас 8,916 зөрчлийн 174.7 сая төгрөг, нийт 288.3 сая төгрөг төлөгдөөгүй байна.

Энэ нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулсан, албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийнхээ биелэлтийг хариуцна” гэж заасныг зөрчсөн байна.

Эрх бүхий албан тушаалтнуудын 2023, 2024 онд оногдуулсан торгуулиас төлөгдөөгүй 708.1 сая төгрөгөөс аудитыг гүйцэтгэх хугацаанд буюу 2025 онд 395.7 сая төгрөг төсөвт төвлөрч 312.4 сая төгрөгийн торгууль хэрэгжээгүй үлджээ.

Эрх бүхий албан тушаалтны хэрэгжүүлээгүй 312.4 сая төгрөгийн торгуулийг барагдуулах талаар аудитын шийдвэрийг холбогдох байгууллагуудад хүргүүллээ.

Аудитаар нийт 455.1 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 42.8 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 412.3 сая төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж хүргүүллээ.

ДҮГНЭЛТ

1. Хүү, торгуулийн орлогыг бодит хэрэгцээ шаардлага судалгаанд үндэслэн төлөвлөхгүй байна.
2. Торгуулийн орлогыг автозамын тухай хууль, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд нийцүүлэн тусгай дансанд төвлөрүүлэлгүй нэгдсэн нэг дансанд төвлөрүүлж байгаа нь эх үүсвэрийг тооцох боломжгүй, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал, замын санд хуулийн дагуу хуваарилахгүй байх нөхцлийг бүрдүүлж байна.
3. Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх 50.4 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт шилжүүлсэн, 708.1 сая төгрөгийн торгуулийг төсөвт төвлөрүүлээгүй байгаа нь эрх бүхий албан тушаалтнууд ногдуулсан торгуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, түүнд тавих хяналт хангалтгүйтэй холбоотой байна.
4. Цахим хэлбэрээр тогтоосон шийтгэвэрийн хэрэгжилт хангалтгүйгээс 288.3 сая төгрөгийн торгууль төсөвт төвлөрөөгүй байна.
5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үйл ажиллагааны төлөвлөгөөний 31 хувь буюу 25 арга хэмжээ хэрэгжээгүй, төлөвлөгөөнд тусгагдаагүй 8 арга хэмжээнд 40.8 сая төгрөг зориулалт бусаар 18.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Аймгийн Засаг даргад:

1. Торгуулийн орлогыг бодит хэрэгцээ шаардлага, судалгаа тооцоонд үндэслэн төлөвлөх
2. Автозамын сангийн тухай хуульд заасан торгуулийн орлогыг тусгай дансанд төвлөрүүлэх
3. Торгуулийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах,

Аймгийн ИТХ-ын даргад:

1. Олон нийтийн цагдаагийн урамшуулал, эрүүл мэндийн даатгалын зардал, Салбар зөвлөлийн орон тооны нарийн бичгийн даргын цалин хөлсний зардлыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын төсөвт тусган төлөвлөх
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд батлагдсан зардлыг үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу зарцуулах,

Цагдаагийн газар, Байгаль орчны газар, Онцгой байдлын газрын дарга нарт:

1. Эрх бүхий албан тушаалтны оногдуулсан торгуулийн орлогын төвлөрүүлэлтэд тавих хяналтыг сайжруулж, хуульд заасан хугацаанд хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах,

Цагдаагийн газрын даргад:

1. Цахим хэлбэрээр тогтоосон шийтгэвэрийн биелэлтийг хангах талаар арга хэмжээ авч ажиллах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:

Аудитын хүрээнд дараах саналыг хүргүүлж байна.

- Зөрчлийн тухай хуулийн 15.24 дүгээр зүйлийн 1-т “Тогтоосон хугацаанд иргэний улсын бүртгэлд бүртгүүлээгүй бол хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэснийг өөрчилж төлбөртэй үйлчилгээ болгох,
- Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 15 дугаар зүйлийн 15.17.3 дахь заалтуудын торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх.
- Торгуулийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сантай болох талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжлан шийдвэрлүүлэх

ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТАЛААР:

- Хэнтий аймгийн Засаг дарга тайлангийн төсөлтэй танилцаж холбогдох саналгүй талаар 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 9/1690 албан бичиг ирүүлсэн.
- Хэнтий аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн даргын 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн ГХ/28 албан бичгээр ирүүлсэн саналыг байгууллагын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэж хүлээн авах боломжгүй гэж шийдвэрлэлээ.



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 08 сарын 14

Дугаар 216-А/2360453-

Чингис хот

Х7А-2025/27-21-УТА-ГА.

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Хэнтий аймгийн Онцгой байдлын газрын эрх бүхий албан тушаалтан нь 2023-2024 онд 21 зөрчилд оногдуулсан 14.1 сая төгрөгийн торгуулийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй, дараагийн шатны арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 1-д "Эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулсан албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийнхээ биелэлтийг хариуцна", 7.5 дугаар зүйлийн 8-д Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд тогтоосон хугацаанд шийдвэрийг биелүүлээгүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлэхээр эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 7.7 дугаар зүйлд заасан харьяаллын дагуу зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн оршин суугаа /оршин байгаа/ газар, эсхүл тухайн зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн шүүхэд хүсэлт гаргана" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Торгуулийн орлогыг төсөвт төвлөрүүлдэггүй, шийдвэрийнхээ биелэлтийг хариуцаж ажилладаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, хурандаа Ж.Эрдэнэбат-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Г.ЭНХ-АМГАЛАН



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 08 сарын 14

Дугаар 214-А-2360453-

Чингис хот

ХТН-2025/д7-21-УЦТА-РА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Хэнтий аймгийн Байгаль орчны газрын эрх бүхий албан тушаалтан нь 2023-2024 онд 13 зөрчилд оногдуулсан 10.0 сая төгрөгийн торгуулийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй, дараагийн шатны арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 1-д "Эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулсан албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийнхээ биелэлтийг хариуцна", 7.5 дугаар зүйлийн 8-д Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд тогтоосон хугацаанд шийдвэрийг биелүүлээгүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлэхээр эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 7.7 дугаар зүйлд заасан харьяаллын дагуу зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн оршин суугаа /оршин байгаа/ газар, эсхүл тухайн зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн шүүхэд хүсэлт гаргана" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Торгуулийн орлогыг төсөвт төвлөрүүлдэггүй, шийдвэрийнхээ биелэлтийг хариуцаж ажилладаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчны газрын дарга Б.Амгаланбат-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АХЛАХ АУДИТОР

Г.ЭНХ-АМГАЛАН





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 08 сарын 14

Дугаар 218-А/2370449

Чингис хот

ХАА-2025/27-01-УТА-ГА

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Хүү торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хэнтий аймгийн ИТХ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын зарцуулалтад аудитын горим, сорил хэрэгжүүлэхэд Иргэний зөвлөлийн урамшуулалд 8.5 сая төгрөг, цагаатгалын урамшуулалд 1.4 сая төгрөг, шүүхийн үйл ажиллагааг иргэдэд түргэн шуурхай хүргэхэд зориулж киоск машин авахад 6.5 сая төгрөг, УИХ-ын сонгуулийн сургалт, бага хуралд оролцох томилолтын зардалд 1.1 сая төгрөг, шатрын тэмцээн зохион байгуулахад 1.0 сая төгрөг, нийт 18.6 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулжээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5-д "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг дараах чиглэлээр зарцуулна", 46.7-д "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг хууль тогтоомжид зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд батлагдсан төсвийг зориулалт бус зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн ИТХ-ын дарга Б.Цогт-Орших-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Х.ЕРКЕГҮЛ



Монгол улс, Чингис хот, 4-р баг, аймгийн ЗДТГ-ын байр, 7056211

ИРҮҮЛСЭН САНАЛ.



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Залуучуудын гудамж-01, Баянмөнх баг, Хэрлэн сум,
Чингис хот, Хэнтий аймаг, 23000
Утас/Факс: (976) 7056 2151,
Цахим шуудан: infoazdtg@khentii.gov.mn

2025. 08. 15 № 9/1690

танай _____-ны № _____-т

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Хүү, торгуулийн бүрдүүлэлт, зарцуулалтад хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.
Уг төсөлд ямар нэгэн саналгүй болно.

Д.АЮУРБУНЬ

231050765



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ
САЛБАР ЗӨВЛӨЛ**

Аймгийн ЗДТГ-ын байр 304 тоот, Сариг баг,
Хэрлэн сум, Хэнтий аймаг, 23119

Утас/Факс: 7056 2307

Цахим шуудан: khural.khentii1992@gmail.com

2025.08.21 № ГХ/28

танай _____-ны № _____-т

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж, дараах саналыг хүргүүлж байна.

2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр хийгдсэн 1,000,000 (нэг сая) төгрөгийн гүйлгээ нь иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хууль сурталчлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгоор шатрын тэмцээн зохион байгуулсан зардал болно.

Энэхүү арга хэмжээ нь Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.2.6-д заасан ерөнхий чиглэлийг хэрэгжүүлэхийн тулд, тус хуулийн 46.5.1-д заасны дагуу зарцуулсан бөгөөд уг зардлыг зориулалтын бус гэж үзэх нь үндэслэлгүй гэж үзэж байна.

АЙМАГТ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Б.ЦОГТ-ОРШИХ



2325130006